

Стэнфорд эрүүл мэндийн төвөөс Эмиривил хотод АЭМҮ-р үйлчлүүлэгчдэд хийгдэж буй Ковид-19 н шинжилгээнд машинтайгаа ирж хамрагдах заавар зөвлөмж

Хаяг: 5818 Peladeau Street, Emeryville, CA 94608

Powell гудамжны хойд талд байрлах Peladeau гудамжинд улаан хүрэн өнгийн олон давхар машины зогсоол байгаа.



- **Scheduled testing гэсэн тэмдэг таны баруун гар талд байгаа.**
- Байшингийн үүдэнд байгаа Стэнфордын ажилтан таньд удирдан зааварчлах болно.
- **Шинжилгээ хийгдэж байгаа газар нийтийн жорлон байхгүйг анхаарна уу.**

Өвчтөнд өгөх заавар:

1. Шинжилгээ хийж байгаа талбайд өөрийн машинтайгаа ирж, удирдамж/зааварчилга өгөх хүртэл машиндаа хүлээгээрэй.
2. Зурагтай үнэмлэхээ үзүүлнэ үү.
 - #1: Машиныхаа бүх цонхыг хаагаарай.
 - #2: Та Ковид-19 н шинжилгээ өгөхөөр ирсэн үү? **Тийм:** 🇺🇸 **Үгүй:** 🇬🇧
 - #3: Та шинжилгээ өгөх цаг товлолтой юу? **Тийм:** 🇺🇸 **Үгүй:** 🇬🇧
3. Бүртгэлийн газар очоод, иргэний үнэмлэхээ харуулаарай.
4. Тэд таны үнэмлэхийг машины цонхоор шалгасны дараа тусгай хамгаалалтын хувцастай эмнэлгийн ажилтнууд зааварчилгааны багц, сорьцын шошгыг таньд өгнө.
5. Эдгээрийг шинжилгээний сорьц цуглуулагчид өгөөрэй.
6. Машинтайгаа сорьц цуглуулж байгаа газар очиж, өөрийнхөө ээлжийг хүлээнэ үү. Хамгаалалтын хувцастай эрүүл мэндийн ажилчин таны нэр, төрсөн он сар өдрийг асуух тул машиныхаа цонхыг доошлуулахыг таниас асуух тул цонхоо онгойлгож өгөөрэй. Эмнэлгийн ажилтнууд өвчтөний шошгыг таниас хүлээж авах болно.
7. Эмнэлгийн ажилтан шинжилгээ хийх арчдасыг яаж хийхийг тайлбарлаж, таниас арчдас авна.
 - a. Бид таниас өнөөдөр КОВИД-19-н арчдас авах болно. Бид энэ арчдасыг таны хамар руу гүн оруулах болно (зураг дээрх шиг). Зарим хүмүүст энэ нь эвгүй



байдаг, гэхдээ 10 секунд л болно.

- b. Ханиалгах, загатнах нь хэвийн үзэгдэл юм. Хэрэв таньд бөөлжих уут хэрэгтэй бол бидэнд мэдэгдээрэй.
- c. Дээшээ харан, толгойгоо арагш нь болгоорой.

Стэнфорд эрүүл мэндийн төвөөс Эмиривил хотод АЭМҮ-р үйлчлүүлэгчдэд хийгдэж буй Ковид-19 н шинжилгээнд машинтайгаа ирж хамрагдах заавар зөвлөмж

8. Хөдөлгөөнгүй байж, амаараа амьсгалаарай. Та шинжилгээгээ өгөөд дуусчихлаа, одоо гэртээ харьж болно. Таньд шинжилгээний хариуг эмч тань утасдаж мэдэгдэнэ, тэр хүртэл тусгаарлах зааврыг дагаарай. Аламеда дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Коронавирус-2019 (КОВИД-19) халдвартай хүмүүст зориулсан тусгаарлалт ба хорио цээрийн зааварчилгааг доорх холбоос руу орж уншаарай:

<http://www.acphd.org/media/568835/covid-19-health-officer-order-packet-2020.04.15-english.pdf>

Анхаарах: энэ цаг товлолт нь зөвхөн шинжилгээ хийхэд зориулагдсан болно. Эрүүл мэндтэй холбоотой асуулт байвал өөрийнхөө эмч рүү залгаж асуугаарай. Шинжилгээг хийхдээ (хамарын гүн рүү) тусгай хамгаалалтын хувцастай эрүүл мэндийн ажилтан хийнэ.

- Шинжилгээгээ өгч дуусангуутаа шууд гэртээ хариарай.
- Шинжилгээний хариу ажлын 2 хоногийн дотор гарна. АЭМҮ-с шинжилгээний хариуг тань руу утасдаж мэдэгдэнэ. Шинжилгээий хариу гартал гэртээ байж, бусад хүмүүстэй холбоо барихаас сэргийлээрэй.
- Өвчнийг хянах төв (CDC), урьдчилан сэргийлэх вэбсайт руу дараах хаягаар орж мэдээлэлтэй танилцаарай: <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/if-you-aresick/steps-when-sick.html>.

Шинжилгээ нь төгс биш бөгөөд таны шинжилгээий үр дүн буруу буюу вурисгүй гэж гарах магадлалтайг анхаарна уу. Тийм учраас шинж тэмдгүүдээ сайтар ажиглаж, хэд хоногийн дотор таны бие сайжрахгүй эсвэл муудвал АЭМҮ-рүү утасдаж холбоо бариарай.

Машинтайгаа ирж шинжилгээнд хамрагдах газрын хаяг болон чиглэл

Хаяг: *5818 Peladeau St, Emeryville CA*

580 West- хурдны замаар ирэх бол

- I-580W-хурдны зам руу ороод
- Баруун гар талын 2 эгнээгээр I-580W/I-80 E руу хурдны замаас гарах гарц Berkeley/Sacramento руу орох
- Баруун талын эгнээгээр гарц 9 р, Powell St/Emeryville тэмдгийг даган үргэлжлүүлэн яваарай
- Хурдны замаасаа Powell Street гарцаар гараарай
- Баруун гар талын 2 эгнээг ашиглан баруун тийш эргэн Powell St- руу ороорой
- Hollis Street -р зүүн эргээрэй
- 59th Street -рүү зүүн эргээрэй
- Зүүн эргэж Peladeau Street- руу ороорой
- Peladeau гудамжны баруун гар талд байгаа цаг товлолттой шинжилгээ хийх тэмдгийг харах хүртлээ үргэлжлүүлэн яваарай. Стэнфордын эмнэлгийн ажилтан таньд зааварчилгаа өгөхөөр үүдэнд хүлээж байх болно.

Стэнфорд эрүүл мэндийн төвөөс Эмиривил хотод АЭМҮ-р үйлчлүүлэгчдэд хийгдэж буй Ковид-19 н шинжилгээнд машинтайгаа ирж хамрагдах заавар зөвлөмж

80 West-хурдны замаар ирэх бол

- Гарц 10- р Ashby Avenue-р гараарай
- Ashby Avenue N -р үргэлжлүүлэн яваарай
- Баруун тийш эргэж 7th Street -руу ороорой
- Баруун эргэж Folger Avenue -руу ороорой
- Зүүн эргэж Hollis Street -руу ороорой
- Баруун эргэж 59th Street -руу ороорой
- Зүүн эргэж Peladeau Street -руу ороорой
- Peladeau гудамжны баруун гар талд цаг товлоттой шинжилгээ хийх тэмдгийг харах хүртлээ үргэлжлүүлэн яваарай.Стэнфордын эмнэлгийн ажилтан таньд зааварчилгаа өгөхөөр үүдэнд хүлээж байх болно.

80 East- хурдны замаар ирэх бол

- 101 South хурдны замруу орох
- Зүүн 2 эгнээг ашиглан Bay Bridge/Oakland руу гарах улс хоорондын 80 гарцаар гарна уу
- I-80 E -р үргэлжлүүлэн яваарай
- Гарц 9 хүртэл баруун эгнээгээр явж байгаад, Powell St/Emeryville тэмдгийг дагаарай
- Powell Street гарцаар гарна
- Баруун 2 эгнээг ашиглан Powell St -р баруун тийш гарна уу
- Hollis Street- р баруун эргэ
- 59th Street- р зүүн эргэ
- Peladeau Street- р зүүн эргэ
- Peladeau гудамжны баруун гар талд цаг товлоттой шинжилгээ хийх тэмдгийг харах хүртлээ үргэлжлүүлэн яваарай.Стэнфордын эмнэлгийн ажилтан таньд зааварчилгаа өгөхөөр үүдэнд хүлээж байх болно.

880 North- хурдны замаар ирэх бол

- I-880 N хурдны замруу орох
- Баруун 2 эгнээг ашиглан CA-24/Walnut Creek руу 45A гарцаар I- 980 руу гарна уу
- I-980 E- р үргэлжлүүлэн яваарай
- Баруун 2 эгнээг ашиглан гарц San Francisco руу гарна
- I-580 W хурдны замруу орно
- Баруун 2 эгнээг ашиглан I-580 W/I-80 E гарцаар Berkeley/Sacramento руу гараарай
- Exit 9 хүртэл баруун эгнээгээрэй явж байгаад, Powell St/Emeryville тэмдгийг дагаарай
- Powell Street гарцаар хурдны замаас гараарай
- Powell St- р баруун эргэхийн тулд баруун 2 эгнээг ашиглана уу
- Hollis Street- р зүүн эргэ
- 59th Street- р зүүн эргэ
- Peladeau Street- р зүүн эргэ
- Peladeau гудамжны баруун гар талд цаг товлоттой шинжилгээ хийх тэмдгийг харах хүртлээ үргэлжлүүлэн яваарай.Стэнфордын эмнэлгийн ажилтан таньд зааварчилгаа өгөхөөр үүдэнд хүлээж байх болно.